

# Б-СӨБ-1 маягтын үзүүлэлтийг системээс гаргах зааварчилгаа

## Б-СӨБ-1 тайлангийн маягтын үзүүлэлтийг системээс гаргах зааварчилгаа

### 1. Үндсэн сургалтад хамрагдаж байгаа хүүхэд болон бүлгийг тоолохдоо

Боловсролын удирдлагын системийн “**Сургалтын хөтөлбөр**” үйл ажиллагааны 'Хөтөлбөрийн төрөл (Program type) талбар нь СӨБ-Сургуулийн өмнөх боловсрол-Хувилбарт гэсэн сонголтоос бусад хөтөлбөр сонгогдсон, сургалтын хэлбэр (Academic shift) талбар нь Үндсэн гэж сонгогдсон, “**Анги, бүлэг**” үйл ажиллагааны Бүлгийн төрөл (Student group type) талбар нь хөтөлбөрийн бүлэг гэж сонгогдсон, Бүлгийн ангилал (Group student classification) талбар нь үндсэн бүлэг гэж сонгогдсон дараах бүлэг болон бүлэгт суралцаж байгаа суралцагч

- Бүлэг нь Бага үзүүлэлтэд 'Суралцагчийн түвшин (Academic level) (анги) талбар нь Бага, Ясли гэж сонгогдсон бүлэг болон бүлэгт хамаарах суралцагчийг
- Бүлэг нь Дунд үзүүлэлтэд 'Суралцагчийн түвшин (Academic level) (анги) талбар нь Дунд гэж сонгогдсон бүлэг болон бүлэгт хамаарах суралцагчийг
- Бүлэг нь Ахлах үзүүлэлтэд 'Суралцагчийн түвшин (Academic level) (анги) талбар нь Ахлах гэж сонгогдсон бүлэг болон бүлэгт хамаарах суралцагчийг
- Бүлэг нь Бэлтгэл үзүүлэлтэд 'Суралцагчийн түвшин (Academic level) (анги) талбар нь Бэлтгэл гэж сонгогдсон бүлэг болон бүлэгт хамаарах суралцагчийг
- Бүлэг нь Холимог үзүүлэлтэд Боловсролын удирдлагын системийн “**Сургалтын хөтөлбөр**” үйл ажиллагааны 'Хөтөлбөрийн төрөл (Program type) талбар нь СӨБ-Сургуулийн өмнөх боловсрол-Хувилбарт гэсэн сонголтоос бусад хөтөлбөр сонгогдсон, сургалтын хэлбэр (Academic shift) талбар нь Үндсэн гэж сонгогдсон, “**Анги, бүлэг**” үйл ажиллагааны Бүлгийн төрөл (Student group type) талбар нь Холимог бүлэг гэж сонгогдсон, Бүлгийн ангилал (Group student classification) талбар нь үндсэн бүлэг гэж сонгогдсон дараах бүлэг болон бүлэгт суралцаж байгаа суралцагч

### 2. Хувилбарт сургалтад хамрагдаж байгаа хүүхэд болон бүлгийг тоолохдоо

Боловсролын удирдлагын системийн “**Сургалтын хөтөлбөр**” үйл ажиллагааны 'Хөтөлбөрийн төрөл (Program type) талбар нь СӨБ-Сургуулийн өмнөх боловсрол-Хувилбарт гэж сонгогдсон, сургалтын хэлбэр (Academic shift) талбар нь Хувилбарт гэж сонгогдсон дараах бүлэг болон бүлэгт суралцаж байгаа суралцагч

- Бүлэг нь Ээлжийн үзүүлэлтэд бүлгийн ангилал талбар нь Ээлжийн бүлэг гэж сонгогдсон бүлэг болон бүлэгт хамаарах суралцагчийг

- Бүлэг нь Нүүдлийн үзүүлэлтэд бүлгийн ангилал талбар нь Нүүдлийн бүлэг гэж сонгогдсон бүлэг болон бүлэгт хамаарах суралцагчийг
- Бүлэг нь Явуулын багшийн сургалтанд хамрагдагчид үзүүлэлтэд бүлгийн ангилал талбар нь Явуулын бүлэг гэж сонгогдсон бүлэгт хамаарах суралцагчийг

**Анхаарах нь:** Хувилбартын бүлэгт олон түвшний суралцагч суралцдаг бол хувилбартын бүлгийг үүсгэхдээ бүлгийн төрөл талбарт холимог сонголтыг сонгож ямар ангийн холимог бүлэг болохыг анги нэмэхээр үүсгэж өгнө.

### **3. Малчдын хүүхэд гэдэгт**

Боловсролын удирдлагын системийн **"Суралцагч"** үйл ажиллагааны 'Суралцагчийн хувийн мэдээлэл-ийн Нэмэлт мэдээлэл хэсгийн Өрхийн мэдээлэл-ийн "Эцэг эхийн аль нэг нь малчин эсэх" талбарт Тийм (чеклэсэн) гэж сонгосон суралцагчийг тоолно.

### **4. Шинээр элссэн хүүхэд гэдэгт**

Боловсролын удирдлагын системийн **"Суралцагч"** үйл ажиллагаанд шинэ суралцагч үйлдлээр системд бүртгэхдээ үйлдлийн шалтгаан талбарт Шинээр элссэн сонголтыг сонгосон суралцагчийг тоолно.

Хэрэв Үйлдлийн шалтгааныг буруу сонгосон бол Боловсролын удирдлагын системийн **"Суралцагч"** үйл ажиллагааны 'Суралцагчийн хувийн мэдээлэл-ийн хөтөлбөр төлөвлөгөө хэсгийн мэдээлэл засах үйдэл хийж Үйлдлийн мэдээлэл хэсгийн өмнөх гурвалжин дээр дарж үйлдлийн шалтгаан талбарын сонголтоос шинээр элссэн сонголтыг сонгоно.

### **5. Халамж эдэлдэг хүүхэд гэдэгт**

Боловсролын удирдлагын системийн **"Суралцагч"** үйл ажиллагааны 'Суралцагчийн хувийн мэдээлэл-ийн Нэмэлт мэдээлэл хэсгийн Өрхийн мэдээлэл-д Хамрагддаг халамжийн үйлчилгээ хэсэгт ядаж нэг халамжийн бүлэг сонгогдсон бичлэгийн дуусах огноо нь 2018/09/01-2019/08/31 хооронд байх бичлэг бүртгэгдсэн суралцагчийг тоолно.

### **6. Бүтэн өнчин хүүхэд гэдэгт**

Боловсролын удирдлагын системийн **"Суралцагч"** үйл ажиллагааны 'Суралцагчийн хувийн мэдээллийн Үндсэн мэдээлэл хэсгийн "Өнчний төрөл" талбарт "Бүтэн өнчин" гэж сонгосон суралцагчийг тоолно.

### **7. Хагас өнчин хүүхэд гэдэгт**

Боловсролын удирдлагын системийн **"Суралцагч"** үйл ажиллагааны 'Суралцагчийн хувийн мэдээллийн Үндсэн мэдээлэл хэсгийн "Өнчний төрөл" талбарт "Хагас өнчин" гэж сонгосон суралцагчийг тоолно.

## **8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд- Төрөл:**

### **- Төрөлхийн**

Боловсролын удирдлагын системийн **"Суралцагч"** үйл ажиллагааны 'Суралцагчийн хувийн мэдээллийн Эрүүл мэнд хэсгийн "хөгжлийн бэрхшээлтэй" талбарт "Үгүй" гэснээс бусдыг сонгосон, төрөл талбарт Төрөлхийн, үндсэн шалтгаан Төрөлхийн гэж сонгогдсон суралцагчийг тоолно.

### **- Олдмол**

Боловсролын удирдлагын системийн **"Суралцагч"** үйл ажиллагааны 'Суралцагчийн хувийн мэдээллийн Эрүүл мэнд хэсгийн "хөгжлийн бэрхшээлтэй" талбарт "Үгүй" гэснээс бусдыг сонгосон, төрөл талбарт Олдмол, үндсэн шалтгаан талбарт Өвчин, Осол, Төрөлхийн сонголтын аль нэг нь сонгогдсон суралцагчийг тоолно.

### **- Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр хэсэгт хэлбэрийн төрлөөс хамаарч**

Боловсролын удирдлагын системийн **"Суралцагч"** үйл ажиллагааны 'Суралцагчийн хувийн мэдээллийн Эрүүл мэнд хэсгийн "хөгжлийн бэрхшээлтэй" талбарт харгалзах төрлийг сонгосон (Харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэцийн, оюуны, аутизм, дауны хам шинж, хавсарсан ) суралцагчийг тоолно.